



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/50

Баянгол

Монгол улсын иргэнд газар
өмчлүүлэх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу газар өмчлөхийг хүссэн нэр бүхий 5 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсүгэй.

2. Гэр бүлийн хэрэгцээнд газраа өмчилж авсан иргэдэд өмчилсөн газрын кадастрын зургийг гаргаж, өмчлөх эрхийг Улсын бүртгэлд бүртгэж, баталгаажуулан гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг газрын даамал /Б.Гэрэлт-Од/- д үүрэг болгосугай.

3. Өмчлөх эрхээ холбогдох хууль тогтоомжийн дагуу баталгаажуулж, өмчилж авсан газартаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хугацаанд нь хийлгэж байхыг газар өмчилж авсан иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР





Сумын Засаг даргын 2017 оны 11
дугаар сарын 08 -ны өдрийн
А/50 дугаар захирамжийн хаваралт

| | Өмчилж авах газрын | | | | | | |
|----|--------------------|-------------------|----------------|-------------------|---|-------------|---------------------|
| | Ургийн овог | Эцэг /эх/-ийн нэр | Өмчлөгчийн нэр | Регистрийн дугаар | Байршил | Хэмжээ /м2/ | Зориулалт |
| 1. | Урианхай | Батдэлгэр | Бөхчулуун | ДП83030112 | Баянгол багийн Ургац хороолол 5-12 тоот | 700 | Гэр бүлийн хэрэгцээ |
| 2. | Харчин | Энхтүвшин | Батхишиг | ДП93102819 | Баянгол багийн Шанд хороолол 5-12 тоот | 700 | Гэр бүлийн хэрэгцээ |
| 3. | Хойд | Даринчулуун | Лхагвадулам | ДП87052702 | Баянгол багийн Шанд хороолол 2-16 тоот | 700 | Гэр бүлийн хэрэгцээ |
| 4. | Урианхай | Намжилжав | Цэцгээ | ДП66012510 | Баянгол багийн Шанд хороолол 6-4 тоот | 700 | Гэр бүлийн хэрэгцээ |
| 5. | Хойд | Ядамцос | Цэвэлдорж | ДП52082116 | Баянгол багийн Шанд хороолол 4-8 тоот | 700 | Гэр бүлийн хэрэгцээ |



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар Н/51

Баянгол

**Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

2. Тус сумд бгт малчин голд галдварт мялаан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийгдэхтэй холбогдуулан сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллага иргэдийг 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр, 15 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Тус сумд вакцин тарих ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд сумын Онцгой комисс ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллага иргэдийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулж вакцинжуулалтын ажилд тагана оролцуулахыг сумын Онцгой комиссын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга /Р.Оюунчимэг/-г дүрмэ болгосугай.

4. Вакцин тарихтын өдөр гутмын мэдээг ОБГ-г хүргэхийг удирдлагын байрны дарга/Р.Оюунчимэг/-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох үүрэг чиглэлээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч /Х.Төртулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  ТУНГАЛАГТАМИР

0/banmt/zahiramj/2 21

00700147

Сумын Засаг даргын 2017 оны
11 дугаар сарын 14-ны өдрийн
4/57 дугаар захирамжийн хавсралт

Баянгол баг

Ажлын хэргийн ажлагч, хянагч Х. Гантулга /Засаг даргын орлогч/
Гишүүд Ч. Гантуяа /Малын эмч/
О. Цэрэнгэл /БМ /Х-ын дарга/
Г. Ган-Очир /Багийн засаг дарга/
Б. Галсанжамц /Мал баригч/
Д. Дунхар-Ийчил /Мал баригч/
Д. Мөнхөө /Мал баригч/

Хамтын хүч баг

Ажлын хэргийн ажлагч, хянагч Б. Гантулга /МӨҮТ мэргэжилтэн/
Гишүүд Д. Ганцэцэг /Малын эмч/
Ж. Ганзориг /Багийн засаг дарга/
Х. Б. Наржаргал /БМ /НХ-ын дарга/
Д. Даринчулуун /Мал баригч/
Б. Нэргүй /Мал баригч/
Н. Лхагвабаяр /Мал баригч/

Сондуулт баг

Ажлын хэргийн ажлагч, хянагч Х. Даваацэрэн /МӨҮТ-ийн дарга/
Гишүүд Ж. Галсан /Малын эмч/
Ц. Даваадорж /Багийн засаг дарга/
О. Цэрэнтогтох /БМ /Х-ын дарга/
Г. Дахишиг /Мал баригч/
Х. Баасандорж /Мал баригч/

Улаантуг баг

Ажлын хэргийн ажлагч, хянагч Баяртолтох /Онцгой байдлын ажилтан/
Гишүүд Т. Сайнхүү /Малын эмч/
Т. Эндэнсүрэн /Хэсгийн төлөөлөгч /
Б. Гантулга /Багийн засаг дарга/
Д. Батбаатар /БМ /НХ-ын дарга/
М. Нарсайхын /Мал баригч/
М. Доржсүрэн /Мал баригч/
Д. Батбаатар /Мал баригч/



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 17 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/52

Баянгол

Г Аж ахуйн нэгж, байгууллагуудын Г
хариуцах нийтийн эдэлбэр
газрын хилийн зааг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, 9.4.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сумын аж ахуйн нэгж, байгууллага хорооллуудад хариуцуулан цас мөс, хог хаягдлыг цэвэрлүүлэх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоосон зураглалыг нэгдүгээр хавсралтаар, нийтийн эдэлбэр газрын цас мөс, хог хаягдлыг цэвэрлэх хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нийтийн эдэлбэр газрын цас мөс, хог хаягдлыг цэвэрлэхгүй байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хорооллын иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг багийн Засаг дарга нар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч, Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжаар тогтоосон нийтийн эдэлбэр газрын цас мөс, хог хаягдлыг баталсан хуваарийн дагуу байнга цэвэрлэхийг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, хорооллын дарга, нар нийт иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР